



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 05 сарын 23 өдөр

Дугаар 157

Улаанбаатар хот

“Ядуу иргэдэд санхүүгийн үйлчилгээг хүргэх төсөл”-ийн
удирдах хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай

Монгол Улсын Сангийн сайдын 2011 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжигдэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ын 7.1.1, төслийн баримт бичгийн хавсралт 4-ийн 2-т заасныг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Ядуу иргэдэд санхүүгийн үйлчилгээг хүргэх төсөл”-ийн Удирдах хороог дараах бүрэлдэхүүнтэй баталсугай:

Дарга

Х.Бум-Эрдэнэ /Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга/

Нарийн бичгийн дарга
бөгөөд гишүүн

Г.Золжаргал /Төслийн хангамж, тайлан хариуцсан зохицуулагч/

Гишүүд:

Б.Батбаяр /Сангийн яамны Санхүү, эдийн засгийн бодлогын газрын дарга/

Н.Оюунчимэг /Санхүүгийн зохицуулах хорооны Бичил санхүүгийн газрын дарга/

Ш.Гоохүү /Монголын хадгаламж, зээлийн хоршоодын холбооны тэргүүн/

Ц.Мягмар-Очир /Монголын хоршооллын сургалт мэдээллийн төвийн гүйцэтгэх захирал/

Ч.Алтангаяа /Монголын хоршооллын үндэсний нэгдсэн холбооны тэргүүлэгч гишүүн/

801502

2. Төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж, үйл ажиллагааны тайлан
хагас, бүтэн жилээр Хороонд тайлагнахыг Удирдах хороо /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН